

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018.12.25

Улаанбаатар хот

№	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗААЛТ	2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭХ ТҮВШИН	ХҮРЭХ ҮР ДҮН	ХАРИУЦАХ НЭГЖИЙН НЭР	БИЕЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1	1.Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримт материалыг тоон хэлбэрт шилжүүлэн, салбар бүрийн цахим мэдээллийн нэгдсэн сан /цахим архив/-г	Байгууллагын ил тод байдлыг хангах	1.1. Байгууллагын захирамжлалын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх	2017 оны байгууллагын даргаас батлагдан гаргасан захирамжлалы н баримт бичгийг цахим хэлбэрт оруулан НАГ-т акт үйлдэж хүлээлгэн өгөх	Байгууллагын ил тод байдал хангагдсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	1.1 Албан хэрэг хөтлөлтийн archive.edoc.mn сайтад байгууллагын захирамжлалын баримт бичгийг 2018 оны байдлаар цахим архив хэлбэрт оруулан хадгалж байна. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх” тухай журмын дагуу ublegal.mn сайтад байгууллагын захирамжлалын баримт бичиг болох тушаал шийдвэрүүдийг мөн 2018 оны байдлаар тухай бүр нь байршуулан ажиллаж байна.	100
			1.2. Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар мэдээллэх	Байгууллагын цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээлэл, газрын даргын тушаал, шилэн дансны тухай Khangardi.mn цахим	Байгууллагын ил тод байдал хангагдсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	1.2 Тус газар нь НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбарын цэвэрлэгээ үйлчилгээ, нутгийн захиргааны байгууллагуудын байрны ашиглалт, инженерийн байгууламжийн хэвийн жигд, найдвартай ажиллагааг хангах, төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэн ажилладаг.	100

				хуудсанд тухайд оруулах	цаг нь			<p>Иймд байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг ил тод байдлын үндсэн 4 чиглэлээр www.khangardi.mn сайтад нээлттэйгээр байршуулан ажиллаж байна. Үүнд:</p> <p>1. Үйл ажиллагааны ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилго, зорилт болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг улирал бүрээр; <p>2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон тухайн жилийн сургалт мэдээллийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар; - Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг байгууллагын ур чадварыг дүгнэх журмын дагуу дүгнэсэн үнэлэгээ; - Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг төрийн албан хаагчдаас авч, шаардлагатай арга хэмжээг авсан тухай мэдээлэл; - Ажлын сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох www.unegui.mn, байгууллагын www.khangardi.mn болон 6 дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан нээлттэй зарласан
--	--	--	--	-------------------------------	-----------	--	--	---

							<p>талаарх мэдээлэл;</p> <p>3. Төсөв, санхүүгийн ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан, мөн өмнөх жилүүдийн байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байршуулж мэдээлсэн; <p>4. Худалдан авах ажиллагааны ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын үнэлгээний хороог байгуулсан тухай түүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан талаар мэдээлэл; - Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг улирал тутам байгууллагын цахим хуудаст тус тус байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. 	
2	2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг байгууллагын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх	2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулах	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч нь 2018 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээг 16 үйл ажиллагаа, 2 тусгай захиалгат бүтээгдэхүүн	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч нь 2018 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 32 арга хэмжээ, 2 тусгай захиалгат бүтээгдэхүүн нийлүүлж, хамтран ажиллахаар гэрээнд гарын үсэг зурсан.	100

			2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнүүлэх	Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн гэрээний биелэлтийг хугацаанд нь гарган холбогдох газарт хүргүүлэх	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	2.2 Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг гарган хүргүүлж байна.	100
3	3. Аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Олон нийтийн арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслолын үйл ажиллагааны үйлчилгээнд зохион байгуулалттайг аар оролцох	3.1. Баяр наадмын үйлчилгээний бэлтгэл ажлыг ханган оролцох	Ардын хувьсгалын 97 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Хүй долоон хутаг, төв цэнгэлдэх хүрээлэн дээр ажиллах тогооч, зөөгч, арын ажилтны нэрсийн жагсаалтыг хуваарийн хамт гаргасан бөгөөд мөн шаардлагатай тооцоо судалгааг гарган санхүүд хүргүүлэх	Олон нийтийн арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслолын үйл ажиллагааны үйлчилгээнд зохион байгуулалттайгаар оролцсон байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	3.1 Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй 7 худагт 340 орчим зочид, төлөөлөгчдөд 12 нэр төрлийн зоогоор, 08-р сарын 4, 5-ны өдрүүдэд “Даншиг наадам-Хүрээ цам 2018”-ын үеэр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, түүний зочид төлөөлөгчид болох нийт 120 гаруй хүнд зоогийн үйлчилгээг тус тус үзүүлсэн.	100
			3.2. Харъяа холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан олон нийтийн арга	НИТХ, НЗД түүний Тамгын газар НЗД-ын хэрэгжүүлэгч агентлагууд зэрэг	Олон нийтийн арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслолын үйл ажиллагааны	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр	3.2 - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит болон ээлжит бус 13 удаагийн чуулганы үйлчилгээ; - 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын	100

			хэмжээнүүдийн үйлчилгээний шаардлагатай бэлтгэл ажлыг ханган оролцох	холбогдох газруудаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнүүдийн үйлчилгээний бэлтгэл ажлыг хангах	үйлчилгээнд зохион байгуулалтта йгаар оролцсон байна.	ашиглалтын алба	Тамгын газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумын үйл ажиллагааны үеэр 1000 сэтгүүлчийн цайны завсарлагын үйлчилгээнд; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачилгаар зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн бүс нутгийн хотуудын дарга нарын форумын үеэр “Чингисийн хүрээ” аялал жуулчлалын цогцолборт болсон бэсрэг наадмын үйл ажиллагааны үйлчилгээ; - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай орон нутгийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөгчид танилцах, туршлага судлах уулзалтанд ирсэн зочидын хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээг 2 удаа тус тус зохион байгууллаа.	
			3.3. Хариуцлагатай жижүүр, эргүүл томилж ажиллуулах, биелэлтийг гаргаж танилцуулах	Баяр наадмын үеэр ажлын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор газрын дарга нийт албан хаагчдыг хариуцлагатай эргүүлээр ажиллуулах хуваарь гарган ажиллах	Олон нийтийн арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслолын үйл ажиллагааны үйлчилгээнд зохион байгуулалтта йгаар оролцсон байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	3.3 Өвөл цагийн горим, нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд байруудын инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах хэрэглээний халуун хүйтэн ус, дулаан цахилгаанаар тасалдалгүй хангах үүднээс хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарийг газрын даргын А/58 дугаар тушаалаар баталж, захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдыг томилон хяналт тавьж, болзошгүй осол, аливаа эрсдлээс	100

							урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг 14 хоног тутам байгууллагын шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажиллаж байна.	
4	4. "Хүүхдэд ээлтэй Улаанбаатар" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах	4.1. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдийн дунд баярын өдөрлөг зохион байгуулж, ажилтнуудын 0-16 насны хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, баярын арга хэмжээ зохион байгуулах	Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, баярын арга хэмжээ зохион байгуулах	Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	4.1 -Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь 2018 оны 12 дугаар сарын байдлаар 289 ажилтан, албан хаагчдын 260 хүүхэд бүртгэлтэй байгаа бөгөөд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын А/53 дугаар тушаалаар эцэг эхийн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын 0-15 насны хүүхдүүдийг баярлуулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бэлгэнд 50 хүүхдийг хамруулсан. - Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын гэр бүл, үр хүүхдийг боловсролтой, амьдрах ухаантай иргэн болгон төлөвшүүлэхэд байгууллагын зүгээс хувь нэмэр оруулж БНХАУ-ын 10 топ дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 9 ажилтны 9 хүүхдийг хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтанд хамруулсан. Мөн тус улсад дипломын мэргэжил олгох 3 жилийн тэтгэлэгт сургалтанд үйлчлэгч П.Батхишигийн хүүхдийг хамруулан бүртгүүлсэн. Уг хөтөлбөрийн сургалт нь	100

							<p>программистын чиглэлээр 3 жилийн хугацаанд сургалт, байрны төлбөргүйгээр сурахын зэрэгцээ, сард 1000 юанын цалинтай суралцах нөхцөлтэй хөтөлбөр юм.</p> <p>- Нийслэлийн Залуучууд хөгжлийн газраас зохион байгуулсан компьютерийн анхан шатны болон фото шоп программын сертификаттай сургалтанд ажилчдын 15 хүүхдийг хамруулсан.</p>	
			<p>4.2. Нийт ажилтан, албан хаагчдын 0-16 насны ангилалын хүүхдүүдийн шинэчилсэн судалгааг хийж, байгууллагаас шинэ жилийн баяраар гарын бэлэг гардуулах</p>	<p>Шинэ жилийн баярыг тохиолдуулан байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж гарын бэлэг гардуулах</p>	<p>Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байуулсан байна.</p>	<p>Захиргаа, санхүүгийн хэлтэс</p>	<p>4.2 Байгууллагын ажилтан, албан хаагчдын 0-16 хүртэлх насны хүүхдийн шинэчилсэн судалгааг гаргаж бүртгэлжүүлсэн. Мөн амьдралын бололцоо муутай, олон хүүхэдтэй албан хаагчийн судалгааг гаргаж НЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бэлгэнд 50 хүүхэд, шинэ жилийн арга хэмжээнд 3 хүүхдийг хамруулсан.</p>	100
5	<p>5. "Аз жаргалтай Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Нийт ажилтан, албан хаагчдын бие бялдрыг эрүүлжүүлэх, зөв амьдралыг хэвшүүлэх зорилгоор "Эрүүл агаар-Аз жаргал" өдөрлөгийг зохион байгуулах</p>	<p>5.1 "Эрүүл агаар-Аз жаргал" өдөрлөгийн хүрээнд нийт ажилтан, албан хаагчдын дунд явган аялал зохион байгуулах</p>	<p>Өдөрлөгт байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг бүрэн идвэхтэй хамруулах</p>	<p>Нийт ажилтан, албан хаагчдын бие бялдар эрүүлжсэн байна.</p>	<p>Захиргаа, санхүүгийн хэлтэс</p>	<p>5.1 Байгууллагын БТС хамтлаг нь Эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал хэвшлийг сурталчилах зорилгоор эрүүл мэндийн өдөрлөгийг Хан-Уул дүүргийн ЭМН-тэй хамтран зохион байгуулж, чихрийн шижинг тодорхойлох үзлэг, цусны даралт ихсэх шалтгаан, зөв хооллолтын талаарх мэргэжлийн зөвлөгөөг өгч ажилласан. Уг өдөрлөгийн арга хэмжээнд манай байгууллагаас гадна НЗДТГ-ын нийт 80 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд эдгээр</p>	100

						<p>хүмүүсийн халдварын бус өвчлөл тусах эрсдлийг үнэлэх, антропометрийн хэмжилт хийн, биеийн жингийн индекс тооцох, цусны даралт хэмжих, биохимийн шинжилгээгээр цусан дахь тос, сахар зэргийг тодорхойллоо.</p> <p>Нийтлэг үйлчилгээний газар нь байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор БТСХамтлагтай хамтран 2018 оны 10 сарын 13-ны бямба гаригт спорт явган аялалыг зохион байгууллаа. Явган аялал Чингэлтэйн автобусны эцсийн буудлаас Чингэлтэй хайрхан уулын оргил хүртэл гэсэн маршрутаар эхэлж ирэх, очих нийт 6 км замд амжилттай алхалаа.</p>	
			<p>5.2. Нийт ажилтан, албан хаагчдын дунд шилжин явах цом бүхий багийн Спортын их наадам зохион байгуулах</p>	<p>Спортын 5 төрлөөр нийт ажилтан, албан хаагчдын дунд уралаан тэмцээн зохион байгуулж шилжин явах цом гардуулах</p>		<p>5.2 - Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын даргын 2018 оны А/30 дугаар тушаалаар баталсан байгууллагын аварга шалгаруулах спортын тэмцээн зохион байгуулах удирдамжийн дагуу Нийтлэг үйлчилгээний газрын БТСХамтлаг нь 2018 оны биеийн тамир спортын наадмыг 04 дүгээр сарын 26-аас 05 дугаар</p>	100

							сарын 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 10 багийн 110 тамирчин сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс 4 төрөлтөөр өрсөлдөж, багийн нийт дүнгээр Г.Энхтуяа ахлагчтай “Шонхорууд” баг 1-р байр, Х.Цогзолмаа ахлагчтай “Харцагууд” баг 2-р байр, Х.Эрдэнэбилэг ахлагчтай “Хангарди” баг 3-р байрыг тус тус эзэлсэн.	
6	6."Эрүүл залуус" аян хэрэгжүүлж, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгон, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.	"Эрүүл залуус" аяны хүрээнд нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	6.1.Аяны хүрээнд нийслэлээс зохион байгуулагдах арга хэмжээнд хамт олныг идвэхтэй хамруулах	Газрын даргын тушаалаар байгууллагын сайн дурын Биеийн тамир спортын хамтлагийг шинэчлэн байгуулж, нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл чийрэг байлгах зорилгоор төлөвлөгөө гарган ажиллах	Нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	6.1- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 15-аас 64 насны хүн амын бие бялдарын хөгжилт, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорилыг 05 дугаар сард авсан бөгөөд нийт ажилтан, албан хаагчдаас 208 хүн буюу 91.25% бүрэн хамрагдаж, 48 хүн 18.75% хүндэтгэх шалтгааны улмаас хамрагдаагүй байна. - Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар-Марафон-2018” олон улсын гүйлтийн тэмцээн 2018 онд тав дахь жилдээ зохион байгуулагдлаа. Энэхүү үйл ажиллагаанд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 82 ажилтан албан хаагчид 5 км зайд идвэхтэй оролцон гүйлээ. - Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын баталсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний хүрээнд батлагдсан хуваарийн дагуу Туул голын эрэг орчмыг цэвэрлэж, 123 шуудай хог, хаягдлыг цуглуулсан.	100

							<p>- Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын “Спорт наадам”-д амжилттай оролцож тэргүүн байрын шагнал “Шилжин явах цом” гардан авсан амжилтыг үзүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын анхдугаар наадамд ажлын байрны дасгал, дартсын төрлөөр амжилттай оролцсон.</p>	
			6.2. Нийт ажилтан, албан хаагчдын дунд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах	Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг бүрэн эрүүл мэндийн багц шинжилгээнд хамруулах			6.2 Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран НҮГ-ын нийт ажилтан, албан хаагчдыг 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны хооронд хэвлийн эхо, ходоодны дуран, рентген, толгой хүзүүний мэс засал, эмэгтэйчүүд, дотор, зүрх судасны нарийн мэргэжлийн эмч нараар хавдрын өвчний урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийлгэж 191 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.	100
7	7. "Ногоон Улаанбаатар 2030" төсөл боловсруулан батлуулж, Улаанбаатар хотыг дэлхийн ногоон хотуудын жишгээр хөгжүүлнэ.	Төслийг дэмжих зорилгоор нийслэлийн засаг захиргааны байруудын гадна орчинг зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	7.1. Дулааны улиралд нийслэлийн засаг захиргааны байруудын гадна орчинг зүлэгжүүлэх	Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн засаг захиргааны байруудын гадна орчинг зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Төслийг дэмжих зорилгоор нийслэлийн засаг захиргааны байруудын гадна орчинг зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	Дотоод хяналт хариуцсан ажилтан Үйлчилгээний алба	7.1 “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд тус газар нь 2018 оныг “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил” болгон зарласан. Энэ хүрээнд “Эрүүл, тохилог ажлын байр” 1 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлаж, НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд, НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон, Мишээл салбаруудын гадна орчинд тохижилт, зүлэгжүүлэлт, суулгац суулгах ажлууд хийгдсэн. Ингэснээр төрийн албан хаагчид	100

							амрах, ая тухтай орчин бүрдсэн гэж үзэж байна.	
8	8. Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх	Стандартчлал, хэмжил зүйн газраар батлуулсан байгууллагын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	8.1.1. Хоол, цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий стандарт CS11-0258:2014 8.1.2. Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээний ерөнхий стандарт CS11-0256:2014 8.1.3. Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ерөнхий стандарт CS11-0257:2014 тус тус стандартуудыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшүүлэх	Хоол, цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий стандарт CS11-0258:2014-ыг зоогийн газрын үйлчилгээний ажилтнууд тогтмол өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллах	Стандартчлал, хэмжил зүйн газраар батлуулсан байгууллагын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.	Дотоод хяналт хариуцсан ажилтан Захиргаа, санхүүгийн алба Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	8.1 Мэргэжлийн байгууллагаар батлагдсан нэр бүхий 3 стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, чанар стандартад нийцсан нийтлэг үйлчилгээг үзүүлж, төрийн албан хаагчдын ажиллах тав тухтай орчинг бүрдүүлэх, байгууллагын үндсэн чиг үүрэгт заасан цэвэрлэгээ үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг бүрэн хангаж ажиллалаа.	100
			8.2. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, биелэлтийг ханган ажиллах	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ерөнхий стандарт CS11-0257:2014 дагуу ХААБ-ын инженер нь шинээр ажилд орж буй ажилтнуудад анхан шатны зааварчилгааг	Стандартчлал, хэмжил зүйн газраар батлуулсан байгууллагын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.	Захиргаа, санхүүгийн алба Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	8.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг 2018 оны 02 сарын 21-ний өдөр газрын даргаар батлуулж, 13 ажил төлөвлөснөөс биелэлтийг шат дарааллан ханган 100 хувь гүйцэтгэн ажилласан байна. Онцлох ажлаас дурдвал: - НМХГ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн мэрэгжилтэн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”	100

				өгч хэвших			<p>сургалт хийлээ.</p> <p>- Нийтлэг үйлчилгээний газар нь тайлант хугацаанд захиргаа санхүүгийн хэлтсийн 38, байр ашиглалтын албаны 32, цэвэрлэгээ үйлчилгээний 148, хоол үйлдвэрлэлийн 26, гадна талбайн үйлчлэгчийн 7, жижүүр 8, нийт 259 ажилтан, албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, болон багаж хэрэгсэлээр бүрэн хангасан.</p> <p>- Нийт ажилтан, албан хаагчид болон шинээр ажилд орсон хүмүүст хөдөлмөр хамгааллын зааварчилгааг өдөр тутам өгч ажиллаж байна.</p>	
--	--	--	--	------------	--	--	---	--

2. Дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

9	9. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, ажлын хариуцлага, уялдаа холбоог эрс сайжруулна.	Байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулж, ажилтан албан хаагчдын ажлыг бодитоор үнэлэх	9.1. Байгууллагын дотоод хяналт шалгалтын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гарган биелэлтийг ханган ажиллах	Байгууллагын дотоод хяналт шалгалтын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан 2017 оны жилийн биелэлтийг газрын даргаар дүгнүүлэн ажиллах	Байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулж, ажилтан албан хаагчдын ажил бодитоор үнэлэгдсэн байна.	Дотоод хяналт хариуцсан ажилтан	9.1 2018 оны дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг томилогдон хяналт-шинжилгээг 9 удаа зохион явуулсан ба өмнөх онд 7 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж байсан нь хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлж, аливаа эрсдэл, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгааг харуулж байна.	100
							Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 3.1.6 дахь заалт /хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч	

						<p>болон олон нийтийн оролцоог хангасан байх/-ын хэрэгжилтийг хангах зорилгоор, зоогийн газруудад санал хүсэлтийн дэвтэр ажиллуулж үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг тогтмол авч ажиллахын зэрэгцээ хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор оны эхэнд буюу 2018 оны 01 дүгээр сард 1556 төрийн албан хаагчаас санал асуулга авч нэгтгэхэд НҮГ-ын үйл ажиллагаанд 49.1% нь сайн, 31.6% нь дунд, 19.3% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна. 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Таныг сонсьё” аяны хүрээнд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбаруудын 1200 орчим төрийн албан хаагч нараас санал хүсэлтийг хүлээн авахад санал асуулгад оролцогчдын 79,3% нь сайн, 17,1% дунд, 3,6% нь хангалтгүй үнэлгээ өгснийг оны эхэнд авсан санал асуулгын дүнтэй харьцуулахад үнэлгээ харьцангуй өссөн байна. Энэ нь өмнөх санал асуулгын дүнгийн мөрөөр хэрэгжүүлж ажилласан ажлын үр дүн гэж үзэж байна. Санал асуулгын үр дүнг тухай бүр нь газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, санал хүсэлт, гомдлын мөрөөр ажиллах үүрэг, даалгаврын дагуу биелэлтийг хангаж, санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажилласан.</p> <p>Мөн өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг 10 дугаар сард хаалттай 10, нээлттэй 1</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>асуултын хүрээнд авлаа. Тус судалгаанд 218 буюу нийт ажилтан, албан хаагчдын 83,5% нь хамрагдаж, байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн хүртээмж, удирдлагын харилцааны ёс зүй, ажилтан, албан хаагчдад тулгарч буй асуудлыг түргэн шуурхай шийддэг байдал, хамтран ажиллагсад болон ажлын орчин, нөхцлийн талаарх санал асуулгад 82,6% сайн, 14,2% нь дунд, 3,2% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байгаа нь ажилтан, албан хаагчид захиргаанаас зохион байгуулж байгаа ажил, удирдлагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгааг харууллаа.</p> <p>Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд НҮГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтад авах арга хэмжээ, түүний хариуцлагын тогтолцоог ур чадварын нэмэгдэлтэй нь уялдуулан тооцож байхаар шийдвэрлэж ур чадвар дүгнэх журманд нэмэлт өөрчлөлт оруулсан. Цагийн бүртгэлийг сар бүр гарган, цагийн хоцрогдолтой ажилтан, албан хаагчдад 3 төрлийн сануулах</p>
--	--	--	--	--	--	--

						хуудсыг тарааж, ур чадварын нэмэгдлээс шат дараатайгаар тооцон ажилласнаар 09 дүгээр сараас эхэлсэн энэ ажил үр дүнтэй болж, 10-р сард 58 сануулах хуудас тарааж байсан бол 11-р сарын байдлаар 32 сануулах хуудас тараасан ба ажлын цагийн хоцрогдол, эрт явалт 45%-иар буурсан байна.	
		9.2. Байгууллагын үр ашгийг тооцоолох гүйцэтгэлийн KPI үзүүлэлтийг байгууллагадаа тогтоох	Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэхийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн гэрээний биелэлтийг үнэл дүгнэхэд энэхүү аргачлалыг баримтлан ажиллах	Байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулж, ажилтан албан хаагчдын ажил бодитоор үнэлэгдсэн байна.	Дотоод хяналт хариуцсан ажилтан	9.2 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг /KPI/-ээр үнэлэх шалгуур үзүүлэлтийг дүрмээр хүлээсэн үндсэн 3 чиг үүргийн хүрээнд нийцүүлэн тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёолол, загварчлалыг гаргаж 2017, 2018 оны үйл ажиллагааны үнэлгээг үнэлсэн. Бидний гаргасан томъёоллоос үнэлгээг харьцуулж харахад 2018 онд үнэлгээ өссөн харагдаж байгаа хэдий ч шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёо, аргачлалыг дахин нягтлах, мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө авч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.	100

10	<p>10. Нийслэлийн хүн амын хүнсний эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулж, бодлогын хэрэгжилтийг хангана.</p>	<p>Нийслэлийн засаг захиргааны байруудын зоогийн газруудаар үйлчлүүлэх ТАХ-дын хүнсний хэрэгцээнд эрүүл ахуйн стандарт аюулгүй байдлын шаардлага хангасан чанартай баталгаат бүтээгдэхүүнээр үйлчлэх</p>	<p>10.1. Хүнсний эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс чанарын шаардлага хангасан баталгаатай аж ахуй нэгжүүдтэй хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллах</p>	<p>Зоогийн газрын хүндэтгэлийн хүлээн авалт, зоогийн үйлчилгээнд чанарын шаардлага хангасан баталгаатай аж ахуй нэгжүүдээс нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнээр ханган ажиллах</p>	<p>Нийслэлийн засаг захиргааны байруудын зоогийн газруудаар үйлчлүүлэх ТАХ-чид эрүүл ахуйн стандарт аюулгүй байдлын шаардлага хангасан чанартай баталгаат бүтээгдэхүүнээр үйлчлүүлсэн байна.</p>	<p>Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба</p>	<p>10.1 Хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангаж ажиллах, чанарын баталгаат бүтээгдэхүүнээр хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор бэлтгэн нийлүүлэгчийн нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын баталгаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байдлыг харгалзан, шууд худалдан авалтын болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, шалгарсан 6 байгууллагатай бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх гэрээ, худалдах-худалдан авах гэрээ байгуулан, талуудыг хариуцлагажуулан ажиллаж байна. Мөн хоол үйлдвэрлэлд бараа бүтээгдэхүүн сонгохдоо импортын бүтээгдэхүүнээс илүүтэй дотоодын тэр дундаа шууд боловсруулан хэрэглэх, эрүүл ахуйн стандарт аюулгүй байдлын шаардлага хангасан баталгаатай бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна.</p>	100
			<p>10.2. Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч, хэрэглэгчдээс ирсэн саналыг үйл ажиллагаандаа тусган ажиллах</p>	<p>Зоогийн үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийн ирүүлсэн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах</p>			<p>10.2 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 3.1.6 дахь заалт /хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх/-ын хэрэгжилтийг хангах зорилгоор, зоогийн газруудад санал хүсэлтийн дэвтэр ажиллуулж үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг тогтмол авч ажиллахын зэрэгцээ хэрэглэгчийн үнэлгээг тогтоох</p>	100

							<p>зорилгоор оны эхэнд буюу 2018 оны 01 дүгээр сард 1556 төрийн албан хаагчаас санал асуулга авч нэгтгэхэд НҮГ-ын үйл ажиллагаанд 49.1% нь сайн, 31.6% нь дунд, 19.3% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна.</p> <p>2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Таныг сонсьё” аяны хүрээнд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбаруудын 1200 орчим төрийн албан хаагч нараас санал хүсэлтийг хүлээн авахад санал асуулгад оролцогчдын 79,3% нь сайн, 17,1% дунд, 3,6% нь хангалтгүй үнэлгээ өгснийг оны эхэнд авсан санал асуулгын дүнтэй харьцуулахад үнэлгээ харьцангуй өссөн байна. Энэ нь өмнөх санал асуулгын дүнгийн мөрөөр авсан арга хэмжээний үр дүн гэж үзэх байна.</p> <p>Үйлчлүүлэгчдээс авсан нээлттэй 1 асуулгаас үзэхэд хоолны амт чанар, нэр төрөл, порц хэмжээ, үйлчилгээний харилцаа, хооллох газрын орчны тохижилт тус тус сайжирсан зэрэг олон өөрчлөлтийг сайшаасан байлаа. Мөн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлд анхаарч өглөөний цайны цэсийг гарган үйлчилж байгаа нь олон үйлчлүүлэгчээс сайшаал хүртсэн оновчтой ажлын нэг болсон.</p>	
11	11. Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.	Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарах тайлан, мэдээ судалгааг үнэн зөв шуурхай	11.1. Жил улирлын тайлан баланс /цалин, НДШ/ гаргаж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	Тайлан, баланс, төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж тайлант хугацаанд нь	Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарах тайлан, мэдээ, судалгаа үнэн	Захиргаа, санхүүгийн хэлтэс	11.1 2018 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийг	100

		гаргаж, аудитын байгууллагаар үйл ажиллагаагаа дүгнүүлж ажиллана.	хугацаанд нь Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Татварын газарт тушаах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Татварын газарт хүргүүлж, агентлагуудад санхүү бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан нягтлан бодогч нараар дамжуулан үзүүлж, анхан шатны нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтлөн ажиллах	зөв шуурхай		батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб сайтад 3 төрлийн тайланг хугацаанд нь сар бүр байршуулан ажилласан.	
			11.2. Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор газрын даргын тушаалаар Тооллогын комисс байгуулж, тооллогыг хагас бүтэн жилээр хийх	Газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглалтанд хяналт тавьж эд хөрөнгийн тооллого хийж нийт эд хөрөнгө хогшилд бүртгэл хийж картжуулах.	Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарах тайлан, мэдээ, судалгаа үнэн зөв шуурхай	Захиргаа, санхүүгийн хэлтэс	11.2 НҮГ-ын 2018 оны А/55 тушаалаар Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн байгуулж, хагас бүтэн жилийн тооллогын комиссыг Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга С.Доржсүрэнгээр ахлуулсан бүрэлдэхүүн хуваарийн дагуу ажилласан. Хагас жилийн байдлаар актлах хөрөнгө болон бүртгэлтэй, бүртгэлгүй хөрөнгийн судалгааг гаргаж 87 төрлийн 14 659 815 төгрөгийн аж ахуйн эд материалуудыг газрын даргын А/57 дугаар тушаалаар акталсан ба жилийн эцсийн тооллогыг ажлын хэсэг батлагдсан	100

							хуваарийн дагуу гүйцэтгэж байна.	
12	12. НЗЗ-ны байруудын хуралдааны, хүндэтгэлийн, сургалтын танхимуудын ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах	Танхимуудын ашиглалтыг батлагдсан журмын дагуу зохицуулах	12.1. Хуралдааны танхимд явагдах арга хэмжээний захиалгыг урьдчилан авч графикт оруулж хөнгөн шуурхай үйлчилнэ.	Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байрны 14 давхрын хурлын танхимуудын техник хэрэгслийг тухай бүрд нь доголдолгүйгээр ажиллуулах	Танхимуудын ашиглалтыг батлагдсан журмын дагуу зохицуулан, давхцал чирэгдэлгүй ажилласан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	12.1 НЗЗ-ны 1, 2, 5-р байруудын хурлын танхимуудад тайлант хугацаанд нийт 1956 хурал, зөвлөгөөн, арга хэмжээ, хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсанаас НЗЗ-ны 1 дүгээр байрны "А" танхимд 538 удаа, "Б" танхимд 219 удаа, Вип танхимд 133 удаа, 2 дугаар байранд 700 удаа, 5 дугаар байрны хурлын танхимд 292 удаа тус тус явагдсан байна.	100
			12.2. Хуралдааны өмнөх цэвэрлэгээ, техник хэрэгслийн хэвийн ажиллагааны бэлтгэлийг бүрэн хангана.	Хуралдааны өмнөх цэвэрлэгээ, техник хэрэгслийн үйлчилгээний бэлтгэлийг бүрэн хангаж, тайлант хугацаанд элдэв зөрчилгүй ажиллах	Танхимуудын ашиглалтыг батлагдсан журмын дагуу зохицуулан, давхцал чирэгдэлгүй ажилласан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	12.2 Тайлант хугацаанд 1956 удаагийн хурал, зөвлөгөөн, арга хэмжээ, хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан танхимуудын цэвэрлэгээ үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж, гомдол саналгүй ажилласан.	100
13	13. Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод, нээлттэй шийдвэрлэнэ.	Байгууллагад хандсан өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх	13.1. Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Тайлант хугацаанд байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд багтаан шуурхай шийдвэрлэн ажиллах	Өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэн ажилласан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	13.1 Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 230 хүсэлт ирснийг "Өргөдөл гомдлын нэгдсэн программ"-д бүртгэж, хуулийн хугацаанд 230 хүсэлтийг шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг сүүлийн 3 жилээр харьцуулхад 2016 онд 4 хоног 10 цаг 19 минут, 2017 онд 6 хоног 0 цаг 32 минут, 2018 онд 4 хоног 11 цаг 41 минут	100

			13.2. Байгууллагын албан хаагчдын ар гэрийн амьдралд гачигдал, хүндрэл тохиолдсон үед дотоод журмын дагуу буцалтгүй тэтгэмж, тусламж олгоно.	Газрын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдын ар гэрт гачигдал, зовлон тохиолдсон үед ажилчдын өргөдлийг үндэслэн газрын даргын тушаалаар буцалтгүй мөнгөн тэтгэмж, тусламж үзүүлэн ажиллах	Өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэн ажилласан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	13.2 Байгууллагаас тусламж, тэтгэмж хүссэн 29 өргөдлийг хууль, дүрэм, газрын дотоод журмын дагуу 100 хувь шийдвэрлэсэн. Мөн 3, 4-р улиралд ажилтан, албан хаагчдын ажлын тогтвор суурьшил, нийгмийн баталгааг хангах үүднээс 90 ажилтанд түлшний хөнгөлөлтөнд 18,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.	100
14	14. Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүчээр хангах замаар төрийн байгууллагуудын эрчим хүчний хэрэглээг хэмнэх бодлого хэрэгжүүлэх	Нийслэлийн засаг захиргааны байруудад эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нэмэгдүүлэх	14.1. НЗЗ-ны байруудын цахилгааны щит, монтаж дулааны шугам, тоолуурыг солих	НЗЗ-ны байрны давхруудын гэрлийг цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй лед гэрэл суурьлуулах	Нийслэлийн засаг захиргааны байруудад эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нэмэгдсэн байна.	Байр ашиглалтын алба	14.1 2018 онд НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг байр ашиглалтын албаны инженерүүд 7 хоног тутам, албаны дарга сард 1 удаа тус тус тогтмол хийж ажилласан. - 5-р байрны А корпус хойд талын жигүүрийн цахилгааны хаалттай хуваарилах байгууламжийн гадна талын ерөнхий кабелийн шугамд гэмтэл гарсаныг дуудлага өгч, мэргэжлийн байгууллагаар гэмтлийг тодорхойлуулж, газар шорооны ажил, холболтын муфьт хийж аюулгүй ажиллагааг хангав. Тус байрны А, Б корпусын хооронд цахилгааны кабель, щит угсарч, цахилгааны ачааллыг бууруулж фазыг тэнцвэржүүлж,	100

						<p>засвар үйлчилгээг хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> - НЗЗ-ны 2 дугаар байрны 2, 4, 5, 6, 9-р давхрын цахилгааны щитны хуваарилах самбарын 32 ампертай нийт 35ш автоматыг шинээр сольж хэвийн ажиллагаатай болгов. - Хангарди ордны нөөц тэжээл болох дизель генераторыг автомат горимд шилжүүлэн АВР сэлгэн залгагчийг бүрэн засварлаж, туршилтын тохируулгыг хийж ажилласан. - Зүүн Цахилгаан түгээх салбартай хамтран ажиллах гэрээний дагуу хуваарилах байгууламжийн тоолуур, гүйдлийн трансформаторыг хэмжилзүйн газраар баталгаажуулсан. 	
		<p>14.2. НЗЗ-ны байруудын нийтийн эзэмшлийн талбайд эрчим хүчийг хэмнэх зорилгоор мэдрэгчтэй гэрлийг суурилуулах /ашиглалттай холбоотой үйлчилгээг хийх/</p>	<p>НЗЗ-ны байруудын гадна талбайн гэрэлтүүлгийг цагийн релед тааруулан эрчим хүчийг хэмнэн ажиллах</p>	<p>Нийслэлийн засаг захиргааны байруудад эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нэмэгдсэн байна.</p>	<p>Байр ашиглалтын алба</p>	<p>14.2 Тайлант хугацаанд техникийн комиссын 68 акт үйлдэж, цахилгаан эрчим хүчийг хэмнэх зорилгоор лед гэрэл 600ш, лед гэрлийн ламп 1600 ш, дросель 50 ш, 1 ба 3 фазын автомат 45ш, шатны мэдрэгчтэй гэрэл 12ш-ыг тус тус сольж, НЗЗ-ны байруудын гадна фасадны гэрэлтүүлэг, рекламн гэрэлтүүлгийг цагийн релегээр удирдах ажиллагааг жигдрүүлснээр 2017 оны мөн үеийн цахилгаан эрчим хүчний зардлаас 16,178,639 төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.</p>	<p>100</p>

15	15. Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авах	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах их цэвэрлэгээнд байгууллага хамт олныг идвэхтэй оролцуулах	15.1. НЗЗ-ны байруудын гаднах орчны цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэр орчинг бүрдүүлэн ажиллах	НЗЗ-ны байруудын гаднах орчны цэвэрлэгээг байр хариуцсан менежерүүд үйлчилгээний ажилтнуудаар тогтмол хийлгэж, цэвэр орчинг бүрдүүлэх	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах их цэвэрлэгээнд байгууллага хамт олныг оролцуулсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба	15.1 Тайлант хугацаанд бүх байруудад их цэвэрлэгээг 262 удаа зохион байгуулсан. НЗЗ-ны байруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийг байр тус бүр сард 2 удаа нийт 24 удаа зохион байгуулсан ба 4-н байрны 15000м2 талбайд мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн. НЗЗ-ны байруудын дээврийн цэвэрлэгээ, ус зайлуулах хоолойн ариутгал цэвэрлэгээг 5-н байранд нийт 48 удаа хийсэн байна. Дээрхи ажлуудыг зохион байгуулснаар бид энэ онд төрийн албан хаагчдын эрүүл, аюулгүй, цэвэр тохилог ажлын байраар бүрэн хангаж, сэтгэлд нийцсэн нийтлэг үйлчилгээг 100% үзүүлж чадсан гэж дүгнэж байна.	100
			15.2. Байгууллагын нийт албан хаагчдыг хавар, намрын их цэвэрлэгээнд бүрэн хамруулан, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас тогтоож өгсөн хуваарьт талбайг байгууллагын нийт ажилтан, албан хаагчид зарлагдсан графикайн дагуу цэвэрлэн ажиллах	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах их цэвэрлэгээнд байгууллага хамт олныг идвэхтэй оролцуулсан байна.	Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба	15.2 Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын баталсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний хүрээнд батлагдсан хуваарийн дагуу Туул голын эрэг орчмыг цэвэрлэж 123 шуудай хог, хаягдлыг цуглуулж идвэхтэй оролцсон.	100

16	16. Нийслэлийн Удирдлагын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргах	Нийслэлийн Удирдлагын зөвлөлөөс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг шуурхай авах	16.1. Үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө хэрэгжилтийг зохион байгуулах	Үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн Ажлын хэсгийн ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу ажиллах	Нийслэлийн Удирдлагын зөвлөлөөс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг шуурхай авч, үндсэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.	Дотоод хяналт хариуцсан ажилтан Захиргаа, санхүүгийн хэлтэс Үйлчилгээний алба Байр ашиглалтын алба	16.1 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу 18 ажил төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 97,5 %-ийн гүйцэтгэлтэй байна.	100
			16.2. Үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэх	Үйл ажиллагааны тайланг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллах			16.2 Байгууллагын эхний хагас жил, бүтэн жилийн тайлан, мэдээг хугацаанд нь гарган холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Хугацаа хоцроосон тайлан мэдээ байхгүй болно.	100
17	17. Төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх	Нийслэлийн засаг захиргааны байруудад хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар үйлчилгээний ажлыг чанартай хийж, гүйцэтгүүлэх	17.1. Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байрны шатыг засварлаж, аюулгүй байдлыг хангах	НЗЗ-ны 4 дүгээр байранд байрлах төрийн албан хаагчид ажиллах, төрийн үйлчилгээ авах иргэдийн үйлчлүүлэх тав тухтай орчин бүрлүүлэх	Нийслэлийн засаг захиргааны байруудад хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар үйлчилгээний ажлыг чанартай хийж,	Байр ашиглалтын алба	17.1 Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/142 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах эрхийг НҮГ-т шилжүүлсэн. Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээр уг ажлын зураг, төсөв хийгдэж батлагдсанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дугаар зүйл,	100

					гүйцэтгүүлэн ажилласан байна.		33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дугаар заалтуудын дагуу Мөнгөн оройт цамхаг ХХК-ийг угсралтын ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан. Тус ажлын явцыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын хяналтын инженерүүдтэй хамтран гүйцэтгэл бүрт хяналт тавьж, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газраас томилогдсон ажлын хэсэг 2018 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн комиссын актаар тус ажлыг хүлээж авсан.	
18	18. Улаанбаатар хотын цэвэр усны сангуудыг шугамаар холбож, цэвэр усны түгээлт, хүртээмжийг сайжруулах	Нийслэлийн засаг захиргааны байруудад хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар үйлчилгээний ажлыг чанартай хийж, гүйцэтгүүлэх	18.1 Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байр буюу Хангарди ордны хэрэглээний халуун усны шугамыг шинээр татах	НЗЗ-ны 2 дугаар байранд үйл ажиллагаагаа явуулж буй НЗД-ын ЗАА, хэрэгжүүлэгч агентлагуудад ажиллаж буй төрийн албан хаагчдын тав тухтай орчин бий болох, цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж буй ажилчдын ажиллах нөхцөл бүрэн хангагдах	Нийслэлийн засаг захиргааны байруудад хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар үйлчилгээний ажлыг чанартай хийж, гүйцэтгүүлэн ажилласан байна.	Байр ашиглалтын алба	18.1 Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээр уг ажлын зураг, төсөв хийгдэж батлагдсанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дугаар заалтуудын дагуу Сагсай өргөө ХХК-ийг угсралтын ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан. Тус ажлын явцыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын хяналтын инженерүүдтэй хамтран гүйцэтгэл бүрт хяналт тавьж, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газраас томилогдсон ажлын хэсэг 2018 оны 12 дүгээр сарын 14-ний өдрийн комиссын актаар тус	100

							ажлыг хүлээж авсан.	
ДУНДАЖ ОНОО								100
НИЙТ ҮНЭЛГЭЭ								100

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ